

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



“МӨНГӨ НӨӨЦ БАЯЛАГ АУДИТ” ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Энхжих мандариваа” Өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ОРА-2022 /1/НА-СТА-БСД

Цахим хуудас: www.audit.mn Орхон аймаг 2022 он	Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах Утас: 7035 9826 Цахим хаяг: orkhon@audit.gov.mn Аудитын менежер: Б.Эрдэнэ Утас: 7035 8505 Цахим хаяг: orkhon@audit.gov.mn Аудитор: Л.Баасандорж Утас: 99055703 Цахим хаяг: mnbaudithhk@gmail.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан (төгрөгөөр).....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн орлого үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
3.Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4. Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
4. Аудитын илрүүлэлт	19
4.1 Залруулсан алдаа	19
4.2 Төлбөрийн акт	19
4.3 Албан шаардлага	20
4.4 Зөвлөмж.....	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ЗГНХ	Засгийн Газрын Нөөц Хөрөнгө
ЗДНХ	Засаг Даргын Нөөц Хөрөнгө
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн Даатгалын Шимтгэл
ӨЭМТ	Өрхийн Эрүүл Мэндийн Төв
ТШЗ	Төсвийн Шууд Захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн Осол, Мэргэжлээс Шалтгаалах Өвчин
ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.03.15 № 101

танай _____ -ны № _____ -т

“ЭНХЖИХ МАНДАРИВАА”
ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА
Г.ЭРДЭНЭТУЯА ТАНАА

Хараат бус аудиторын тайлан

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Энхжих мандариваа” өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Энхжих мандариваа” өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Жижиг дунд аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулаагүй байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

“Энхжих мандариваа” өрхийн эрүүл мэндийн төв нь ЖДААН-ийн СТОУС-д нийцсэн санхүүгийн тайлан, тодруулгуудыг бэлтгээгүй, Төсвийн тухай хуульд нийцүүлэн төсвийн гүйцэтгэлийн тайланг тайлагнаагүй, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж мөрдөөгүй, дотоод хяналтын тогтолцоо сул, өмнөх аудитаар тогтоосон 352.3 мянган төгрөгийн төлбөрийн актыг 2021 оны төсвийн хөрөнгөөр барагдуулсан, цалингийн урамшууллаас даатгуулагч болон ажил олгогчоос төлөх 14,081.0 мянган төгрөгийн НДШ-ийг суутгаж, тайлагнаагүй, улсын төсвийн 262,210.9 мянган төгрөгийн санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар төлөвлөж, гүйцэтгэлийг тайлагнаагүй, 65,552.7 мянган төгрөгийн улсын төсвийн санхүүжилтийг шилэн дансанд мэдээлээгүй, 5,023.7 мянган төгрөгийн татвар, шимтгэлийн тооцоолол,

тайлагналыг алдаатай илэрхийлсэн, 22,851.5 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу, ажил гүйлгээний утга зөрүүтэй, 496.4 мянган төгрөгийн ажил гүйлгээг буруу тайлагнасан, 2,873.7 мянган төгрөгийн Засгийн газраас үзүүлсэн чөлөөлөлтийн орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэлд тусгаагүй, 9,345.0 мянган төгрөгийн бараа материалын зарцуулалтыг бүртгэлд тусгаж, зардлаар хүлээн зөвшөөрөөгүйгээс бараа материалын үлдэгдлийг илүү илэрхийлсэн зэрэг алдаа зөрчлүүд гаргасан байна. Эдгээр 382,787.2 мянган төгрөгийн алдаа зөрчлүүд нь санхүүгийн тайланд өргөн тархсан, материаллаг үр нөлөөтэй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Жижиг дунд аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан (төгрөгөөр)

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	66,501,945.62	177,322,350.83
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	6,054,978.76	2,520,752.29
312	Банканд байгаа бэлэн мөнгө	6,054,978.76	2,520,752.29
3121	Төгрөг	6,054,978.76	2,520,752.29
31213	Арилжааны банк дахь харилцах	6,054,978.76	2,520,752.29
33	АВЛАГА	7,712,812.00	889,893.42
331	Ажиллагчидтай холбогдсон авлага	7,712,275.00	889,893.42
335	Бусад авлага	537.00	
3352	Хувь хүмүүсээс авах авлага	537.00	
35	БАРАА МАТЕРИАЛ	52,394,731.00	173,883,840.28
351	Түүхий эд материал	11,486,736.00	96,073,480.28
3513	Эм боох материал	11,486,736.00	96,073,480.28
354	Хангамжийн материал	40,907,995.00	77,810,360.00
3541	Бичиг хэргийн материал	2,119,390.00	2,916,412.00
3542	Аж ахуйн материал	13,718,360.00	32,819,560.00
3543	Сэлбэг хэрэгсэл	3,426,200.00	4,128,500.00
3547	Бусад хангамжийн материал	21,644,045.00	37,945,888.00
36	НӨӨЦИЙН БАРАА	339,423.86	27,864.84
364	Шатахууны нөөц	339,423.86	27,864.84
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	53,005,097.63	193,564,008.62
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	53,005,097.63	193,564,008.62
392	Биет хөрөнгө	52,441,764.27	193,065,675.24
39203	Авто-тээврийн хэрэгсэл	29,750,000.00	60,907,600.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(9,520,000.04)	(13,533,586.76)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	76,560,536.00	191,221,136.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(47,316,938.07)	(55,675,390.15)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	14,997,500.00	23,616,500.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(12,029,333.62)	(13,470,583.85)
393	Биет бус хөрөнгө	563,333.36	498,333.38
39301	Программ хангамж	650,000.00	650,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(86,666.64)	(151,666.62)
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	119,507,043.25	370,886,359.45
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	5,362,941.86	18,106,427.53
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,362,941.86	630.00
413	Өглөг	5,362,941.86	630.00
4131	Ажилчидтай холбогдсон өглөг	5,362,941.86	630.00
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		18,105,797.53
422	Урт хугацаат зээл		18,105,797.53
4221	Төгрөг		18,105,797.53
42216	Арилжааны банк		18,105,797.53
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	114,144,101.39	352,779,931.92
51	Засгийн газрын хувь оролцоо	114,144,101.39	352,779,931.92
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	26,921,259.00	26,921,259.00
512	Хуримтлагдсан үр дүн	87,222,842.39	325,858,672.92
5121	Өмнөх үеийн үр дүн	87,222,842.39	87,222,842.39
5122	Тайлант үеийн үр дүн		238,635,830.53
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	119,507,043.25	370,886,359.45

2.2 Аудит хийсэн орлого үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	372,493,129.38	1,248,270,254.27
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	64,193,678.38	708,958,668.27
120	Нийтлэг татварын бус орлого	64,193,678.38	706,258,668.27
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	64,193,678.38	706,258,668.27
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,657,000.00	6,741,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,284,864.00	3,726,656.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	59,251,814.38	695,791,012.27
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		2,700,000.00
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого		2,700,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	308,299,451.00	539,311,586.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	269,171,181.00	262,210,956.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	264,621,181.00	262,210,956.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	4,550,000.00	
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	39,128,270.00	277,100,630.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	39,128,270.00	277,100,630.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	315,861,720.80	1,009,634,423.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	315,861,720.80	1,009,634,423.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	312,140,920.80	943,413,783.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	181,532,412.00	196,713,857.35
210101	Үндсэн цалин	181,532,412.00	139,822,198.35
210102	Нэмэгдэл		44,468,980.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		12,422,679.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,135,054.26	22,735,465.84
210201	Тэтгэврийн даатгал	6,093,976.72	17,008,629.24
210202	Тэтгэмжийн даатгал	485,715.66	1,176,604.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	341,532.53	815,565.98
210204	Ажилгүйдлийн даатгал	71,600.96	177,068.14
210205	Эрүүл мэндийн даатгал	3,142,228.39	3,557,598.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,024,890.00	9,450,685.00
210301	Гэрэл, цахилгаан	1,005,477.00	1,965,650.00
210302	Түлш, халаалт	2,520,413.00	6,715,035.00
210303	Цэвэр, бохир ус	499,000.00	770,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,403,774.14	43,867,852.02
210401	Бичиг хэрэг	4,300,958.00	6,470,828.00
210402	Тээвэр, шатахуун	4,550,576.14	6,711,559.02
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	628,950.00	496,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	780,000.00	540,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,967,200.00	3,964,035.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	10,176,090.00	25,684,730.00
2105	Нормативт зардал	64,418,532.38	636,551,913.99
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	64,418,532.38	636,551,913.99
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,484,500.00	4,952,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	395,500.00	
210604	Урсгал засвар	2,089,000.00	4,952,800.00
2107	Томилолт, зочны зардал	1,218,400.00	
210702	Дотоод албан томилолт	1,218,400.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	243,720.00	1,541,420.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		352,300.00
210803	Даатгалын үйлчилгээ		291,340.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	99,900.00	60,080.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	121,820.00	815,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,679,638.02	27,599,789.01
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,889,430.00	13,721,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	8,790,208.02	13,878,289.01
211	ХҮҮ		1,505,797.53
2112	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр		1,505,797.53
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр		1,505,797.53
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,720,800.00	64,714,843.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,720,800.00	64,714,843.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	570,000.00	6,186,240.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,150,800.00	58,528,603.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	56,631,408.58	238,635,830.53
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	56,631,408.58	238,635,830.53

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	320,339,696.00	552,479,242.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,098,640.00	13,167,656.00
120	Нийтлэг татварын бус орлого	8,098,640.00	10,467,656.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,098,640.00	10,467,656.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,657,000.00	6,741,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,284,864.00	3,726,656.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	3,156,776.00	-
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	2,700,000.00
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	-	2,700,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	312,241,056.00	539,311,586.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	269,171,181.00	262,210,956.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	264,621,181.00	262,210,956.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	4,550,000.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	43,069,875.00	277,100,630.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	3,941,605.00	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	39,128,270.00	277,100,630.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	310,276,543.40	533,896,066.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	310,276,543.40	533,896,066.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	302,613,601.40	474,788,287.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	184,331,800.06	202,202,844.11
210101	Үндсэн цалин	184,331,800.06	202,202,844.11
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,146,049.34	22,805,234.36
210201	Тэтгэврийн даатгал	-	16,759,422.72
210202	Тэтгэмжийн даатгал	9,146,049.34	-
210205	Эрүүл мэндийн даатгал	-	6,045,811.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,240,890.00	9,450,685.00
210301	Гэрэл, цахилгаан	1,005,477.00	1,965,650.00
210302	Түлш, халаалт	2,520,413.00	6,715,035.00
210303	Цэвэр, бохир ус	715,000.00	770,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	47,969,770.00	79,681,458.00
210401	Бичиг хэрэг	4,337,060.00	7,301,350.00
210402	Тээвэр, шатахуун	4,840,000.00	6,400,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	628,950.00	496,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	780,000.00	540,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,784,860.00	19,260,878.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	23,598,900.00	45,682,530.00
2105	Нормативт зардал	35,012,842.00	131,111,046.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	35,012,842.00	131,111,046.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,560,700.00	14,274,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,624,300.00	-
210602	Тавилга	-	8,619,000.00
210604	Урсгал засвар	4,936,400.00	5,655,100.00
2107	Томилот, зочны зардал	1,218,400.00	-
210702	Дотоод албан томилот	1,218,400.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	243,720.00	1,541,420.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	352,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	291,340.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	99,900.00	60,080.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	121,820.00	815,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,889,430.00	13,721,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,889,430.00	13,721,500.00
211	ХҮҮ	-	1,505,797.53
2112	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	-	1,505,797.53
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	-	1,505,797.53
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,662,942.00	57,601,981.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,662,942.00	57,601,981.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	3,942,142.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	570,000.00	4,836,240.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,150,800.00	52,765,741.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	10,063,152.60	18,583,176.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	4,230,000.00	40,223,200.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,230,000.00	40,223,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,230,000.00	40,223,200.00
222001	Тоног төхөөрөмж	4,230,000.00	9,065,600.00
223001	Бусад хөрөнгө	-	31,157,600.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(4,230,000.00)	(40,223,200.00)
14	Бусад эх үүсвэр	-	22,120,000.00
145007	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	22,120,000.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	4,014,202.47
230001	Эргэж төлөгдөх зээл	-	4,014,202.47
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ Э	-	18,105,797.53
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	5,833,152.60	(3,534,226.47)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	221,826.16	6,054,978.76
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,054,978.76	2,520,752.29

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын сан	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	26,921,259.00	30,591,433.81	57,512,692.81
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	26,921,259.00	30,591,433.81	57,512,692.81
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт			
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт			
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			
Тайлант үеийн үр дүн		56,631,408.58	56,631,408.58
2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	26,921,259.00	87,222,842.39	114,144,101.39
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	26,921,259.00	87,222,842.39	114,144,101.39
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт			
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт			
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү			
Тайлант үеийн үр дүн		238,635,830.53	238,632,830.53
2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	26,921,259.00	325,858,672.92	352,779,931.92

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Энхжих мандариваа” ӨЭМТ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлийн бодлого, төсвийн төлөвлөлт ба гүйцэтгэл, дотоод хяналт, нийгмийн даатгал, татвар, бараа материал, санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэлийн программ хангамж, орлого, нягтлан бодох бүртгэл, анхан шатны баримт хөтлөлт, шилэн дансны хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Мөнгө Нөөц Баялаг Аудит” ХХК-ийн ахлах аудитор Л.Баасандорж, аудитор З.Баттуяа нар гүйцэтгэж, хяналтыг гүйцэтгэгч талаас тус компанийн чанарын хяналтын менежер М.Бямбадорж, захирал Б.Байгал нар, захиалагч талаас Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Эрдэнэ, газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

“Энхжих мандариваа” ӨЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайланг “Мөнгө Нөөц Баялаг Аудит” ХХК-д 2022 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 25 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

“Энхжих мандариваа” ӨЭМТ нь анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэх үйл ажиллагааны чиглэлтэйгээр 2012 онд байгуулагдсан зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл (ЗБН) юм. Тус нөхөрлөл нь “*Ёс зүйг эрхэмлэж, стандартад нийцсэн чанартай цогц тусламж үйлчилгээг үзүүлэх анхан шатны жишиг эмнэлэг болох*” алсын хараандаа хүрэхийн тулд “*Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг иргэдэд ээлтэй, аюулгүй байдлаар хүргэх, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тэргүүлэх чиглэлтэй, иргэддээ ээлтэй эрүүл мэндийн жишиг төв болно*” гэсэн эрхэм зорилгын тодорхойлж “*Чанартай тусламж-Хүнлэг үйлчилгээ-Эелдэг харилцаа-Эвсэг хамт олон*” гэсэн үйл ажиллагааны чиглэл, зорилтуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын тухай багц хууль, Нийгмийн даатгалын тухай багц хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль, зэрэгт 2021 онд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллага нь дотоод хяналтын нэгж, хариуцсан ажилтангүй бөгөөд тайлант хугацааны дотоод хяналтын үйл ажиллагаа нь төлөвлөлтгүй, хэрэгжүүлэлтийн үеийн нотлох баримтгүй, тайлагнал нь дотоод хяналт шалгалт гэхээсээ илүү үйл ажиллагааны тайлан, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн хэлбэртэй, гүйцэтгэлийн үр дүнг хэмжих үзүүлэлтгүй, дүгнэх боломжгүй, ажлыг сайжруулахад чиглэсэн зөвлөмж тусгагдаагүй, дотоод хяналт шалгалт хийгдсэн эсэхийг дэмжих, нотлох хангалттай бөгөөд зохистой нотолгоогоор аудиторыг хангаагүй болно.

Түүнчлэн 2021 оны 10 дугаар сард Орхон аймгийн санхүүгийн хяналт, аудитын албанаас санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилт, коронавируст халдварын санхүүжилт, зарцуулалт, коронавирусын халдварыг илрүүлэх шинжилгээний үнэ тарифын мөрдөлт, хэрэгжилт, шилэн дансны мэдээллийн хэрэгжилт, нягтлан бодох бүртгэл хөтлөлт зэрэг 8 чиглэлээр хяналт, шалгалтыг зохион байгуулжээ. Тус хяналт шалгалтаар өрхийн эмнэлгүүдийн үйл ажиллагаанд нэмэлт санхүүжилтийн данс нээж ажиллаагүй, нягтлан бодох бүртгэл хөтлөлт иж бүрэн бус, анхан шатны баримтын бүрдэл дутуу, алдаатай, шилэн дансанд мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, хөрөнгө хүлээн авах акт, баталгаажуулалт хийгдээгүй, зарим төлбөргүй үйлчилгээг иргэдэд үнэ төлбөртэй үзүүлсэн, төсвийг үр ашиггүй удирдаж, өр зээл үүсгэн автомашин худалдан авсан, нягтлан бодох бүртгэлээр тавигдах дотоод хяналтын тогтолцоо сул гэсэн дүгнэлтийг өгчээ.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, ЖДААН-ийн СТОУС-д нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан боловсруулагдан боловч тус нөхөрлөлийн санхүүжилтийн тогтолцоо, түүний зарцуулалт, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагнал, толилуулга нь бүхэлдээ УСНББОУС, Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаал “*Журам батлах тухай (Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар)*”, бусад төсөвт байгууллагын хүрээнд дагаж мөрдөгдөж буй эрх зүйн баримт бичгүүдийг дагаж мөрдсөн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэйгээ үл уялдаж байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Энхжих мандариваа” ӨЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг УСНББОУС-ын үзэл баримтлалд тулгуурлан аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн ч энэ нь тус байгууллагын эрх зүйн болон стандартын орчинд үл нийцэж байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр батлагдсан төсөв сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоон тооцсон.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн 495,200.0 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 9,904.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 6,932.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Бид аудитаар тус нөхөрлөлийн 2021 оны 12 дугаар сарын 31-ээр УСНББОУС-ийн үзэл баримтлал, тайлагнал, толилуулгад нийцүүлэн гаргасан санхүүгийн тайланд тулгуурлан тодруулга, тайлбарыг гүйцэтгэлээ.

“Энхжих мандариваа” ӨЭМТ-ийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 251,379.3 мянган төгрөгөөр буюу 210.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө авлага, бараа материал, нөөцийн бараа, үндсэн хөрөнгө, богино ба урт хугацаат өр төлбөр, цэвэр хөрөнгө данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31	Өөрчлөлт	Хувь
Мөнгөн хөрөнгө	6,055.0	2,520.7	(3,534.3)	-58.4
Авлага	7,712.8	889.9	(6,822.9)	-88.5
Урьдчилгаа	-	-	-	-
Бараа материал	52,394.7	173,883.8	121,489.1	231.9
Нөөцийн бараа	339.4	27.9	(331.5)	-91.8
Үндсэн хөрөнгө	53,005.1	193,564.0	140,558.9	265.2
Нийт хөрөнгө	119,507.0	370,886.3	251,379.3	210.3
Өр төлбөр	5,362.9	18,106.4	12,743.5	237.6
Цэвэр хөрөнгө	114,144.1	352,779.9	238,632.8	209.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмч	119,507.0	370,886.3	251,379.3	210.3

Тус нөхөрлөл нь ХААН банканд 1 харилцах данстай бөгөөд тайлант оны эхэнд 6,055.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол тайлант оны эцэст 58.4%-аар буюу 3,534.3 мянган төгрөгөөр буурч, 2,520.7 мянган төгрөг болсон байна. Үүнд 2021 онд тус дансаар 574,599.2 мянган төгрөгийн мөнгөн орлого орж, 578,133.5 мянган төгрөгийн мөнгөн зарлага гарсан нь нөлөөлсөн байна. Мөнгөн орлого нь улсын төсвийн 262,211.0 мянган төгрөгийн санхүүжилт, эрүүл мэндийн даатгалын сангийн 277,100.6 мянган төгрөгийн санхүүжилт, ӨЭМТ-ийн төлбөртэй үйлчилгээний орлого болох шинжилгээ, Ковид 19 илрүүлэх үйлчилгээний орлого 6,741.0 мянган төгрөг, томуу болон Ковид 19 халдварын үед ажилласан эмнэлгийн ажиллагсдад олгох илүү цагийн цалин хөлсний санхүүжилт, эрүүл мэндийн ажиллагсдад үзүүлсэн дэмжлэг, шагнал зэрэг туслах үйл ажиллагаатай холбоотой 3,726.7 мянган төгрөгийн мөнгөн орлого, автомашин худалдан авахтай холбоотой ХААН банкнаас авсан 22,120 мянган төгрөгийн зээлийн мөнгөн орлогоос бүрдэж байна. Харин нийт мөнгөн зарлагын 202,202.8 мянган төгрөг нь цалин хөлстэй холбоотой зардалд, 22,805.2 мянган төгрөг нь ажил олгогчоос төлөгдөж НДШ-ийн зардалд, 9,450.7 мянган төгрөг нь үйл ажиллагаа явуулахтай холбоотой тогтмол зардалд, 79,681.4 мянган төгрөг нь хангамж, бараа материалын зардалд, 131,111.0 мянган төгрөг нь нормативт зардалд, 14,274.1 мянган төгрөг нь эд хогшил, урсгал засварын зардалд, 1,541.2 мянган төгрөг нь бусдаар гүйцэтгүүлсэн төлбөртэй ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд, 13,721.5 мянган төгрөг нь бусад бараа үйлчилгээний зардалд, 1,505.8 мянган төгрөг нь хүүгийн зардалд, 57,602.0 мянган төгрөг нь бусад урсгал шилжүүлэгт, 40,223.2 мянган төгрөг нь үндсэн хөрөнгө орж бэлтгэхэд, 4,014.2 мянган төгрөг нь зээл төлөлтөд тус тус зарцуулагджээ.

Тайлант оны эхэнд тус нөхөрлөл нь 7,712.8 мянган төгрөгийн авлагатай байсан бөгөөд тайлант онд 889.9 мянган төгрөгийн авлага үүсэж, 7,712.8 мянган төгрөгийн авлага

цуглуулагдсанаар авлагын үлдэгдэл 889.9 мянган төгрөг болж өмнөх оноос 6,822.9 мянган төгрөгөөр буюу 88.5%-аар буурсан байна. Үүнд, ажиллагсадтай холбоотой үүссэн авлага 6,822.4 мянган төгрөгөөр буюу 88.5%-аар, бусад хүмүүсээс авах авлага 0.5 мянган төгрөгөөр буюу 100% буурсан нь нөлөөлсөн байна.

Харин тайлант онд 10,919.1 мянган төгрөгийн цалингийн урьдчилгаа олгогдож буцаан суутгагдсанаар урьдчилж гарсан зардал үлдэгдэлгүй толилуулагдсан байна.

2021 онд тус нөхөрлөлийн бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 231.9%-аар буюу 121,489.1 мянган төгрөгөөр өссөн байна. Уг өсөлтөд дараах бараа материалуудын хөдөлгөөн нөлөөлсөн байна. Үүнд:

- Эм боох материал өмнөх оноос 84,586.7 мянган төгрөгөөр буюу 736.4%-аар өсөж 96,073.5 мянган төгрөг болсон байна. Тайлант онд урсгал үйл ажиллагааны санхүүжилтээр 131,111.0 мянган төгрөгийн эм боох материалыг худалдан авсан, мөн 590,196.0 мянган төгрөгийн эм вакцин үнэ төлбөргүй хүлээн авч, нийт 721,307.0 мянган төгрөгийн эм боох материал орлогод авч үүнээс 636,656.3 мянган төгрөгийн материалыг зарцуулжээ. Зарцуулсан материалаас 60.0 мянган төгрөгийн материал цалин хөлсний зардалд, 44.4 мянган төгрөгийн материал аж ахуйн материалын зардалд, 636,551.9 мянган төгрөгийн материал эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардалд зарцуулагдсан байна.
- Бичиг хэргийн материал өмнөх оноос 797.0 мянган төгрөгөөр буюу 37.6%-аар өсөж, тайлант оны эцэст 2,916.4 мянган төгрөг болжээ. Тайлант онд 7,103.3 мянган төгрөгийн бичиг хэргийн материал худалдан авч, үүнээс 33.5 мянган төгрөгийг цалин хөлсний зардалд, 6,470.8 мянган төгрөгийг бичиг хэргийн зардалд зарцуулсан байна.
- Аж ахуйн материал өмнөх оноос 139.2%-аар буюу 19,101.2 мянган төгрөгөөр өсөж, 32,189.6 мянган төгрөг болсон байна. Тайланд онд 43,881.5 мянган төгрөгийн аж ахуйн материал худалдан авч, үүнээс 24,780.3 мянган төгрөгийн материалыг аж ахуйн материалын зардалд зарцуулжээ.
- Сэлбэг хэрэгсэл өмнөх оноос 702.3 мянган төгрөгөөр буюу 20.5%-аар өсөж, оны эцэст 4,128.5 мянган төгрөг болжээ. Тайлант онд тус нөхөрлөл 3,570.6 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл худалдан авч, үүнээс 2,868.3 мянган төгрөгийн материалыг урсгал засварын зардалд зарцуулсан байна.
- Тайлант онд 530.0 мянган төгрөгийн барилгын засварын материал худалдан авч бүгдийг нь урсгал засварын зардалд зарцуулсан байна. Тайлант оны эхэн болон эцэст уг бүлэг материал үлдэгдэлгүй тайлагнагджээ.
- Бусад хангамжийн материал өмнөх оноос 16,301.8 мянган төгрөгөөр буюу 75.3%-аар өсөж, 37,945.9 мянган төгрөг болжээ. Тайлант онд тус нөхөрлөл 20,265.9 мянган төгрөгийн материал худалдан авч, үүнээс 3,964.0 мянган төгрөгийн материалыг бага үнэтэй, түргэн элэгдэх, эд зүйлсийн зардалд зарцуулсан байна.

Нөөцийн бараа өмнөх оноос 311.6 мянган төгрөгөөр буюу 91.8%-аар буурч 27.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болсон байна. Энэ нь тайланд онд 6,400.0 мянган төгрөгөөр шатахуун худалдан авч нөөцөлснөөс 6,711.5 мянган төгрөгийн шатахууныг тээвэр, шатахууны зардалд зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 265.2%-аар буюу 140,558.9 мянган төгрөгөөр өсөж оны эцэст дансны үнэ 193,564.0 мянган төгрөг болсон байна. Үүнд дараах хөрөнгүүдийн хөдөлгөөн, тайлант хугацаанд байгуулсан элэгдлийн зардал зэрэг нөлөөлсөн байна.

- Тайлант онд тээврийн хэрэгсэл дансны анхны өртөг өмнөх оноос 31,157.6 мянган төгрөгөөр буюу 104.7%-аар, хуримтлагдсан элэгдэл 42.2%-аар буюу 4,013.6 мянган

төгрөгөөр, дансны үнэ 27,144.0 мянган төгрөгөөр буюу 146.9%-аар тус тус өссөн байна. Үүнд тайлант онд 31,157.6 мянган төгрөгөөр Prius 41 маркийн автомашин худалдан авсан, 4,013.6 мянган төгрөгийн элэгдлийг уг бүлэг хөрөнгөд байгуулсан зэрэг нөлөөлсөн байна.

- Тоног төхөөрөмжийн анхны өртөг өмнөх оноос 114,660.6 мянган төгрөгөөр буюу 149.8%-аар, хуримтлагдсан элэгдэл 8,358.5 мянган төгрөгөөр буюу 17.7%-аар, дансны үнэ 106,302.1 мянган төгрөгөөр буюу 167.4%-аар тус тус өссөн байна. Тайлант онд 23 ширхэг 114,660.6 мянган төгрөгийн анхны өртөг бүхий тоног төхөөрөмжүүдийг орлогод авсны 9,065.6 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авч, үлдсэн 105,595.0 мянган төгрөгийн 16 нэр төрлийн хөрөнгийг өрхийн эрүүл мэндийн төвүүдэд шаардагдах хөрөнгийн санхүүжилтээр үнэ төлбөргүй хүлээн авсан байна. Тайлант онд уг бүлэг хөрөнгөд 8,358.4 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан байна.
- Тавилга эд хогшлын анхны өртөг өмнөх оноос 8,619.0 мянган төгрөгөөр буюу 57.5%-аар, хуримтлагдсан элэгдэл 1,441.3 мянган төгрөгөөр буюу 12%-аар, дансны үнэ 7,177.7 мянган төгрөгөөр буюу 69.5%-аар тус тус өссөн байна. Тайлант онд тус бүлэг хөрөнгөд 1,441.2 мянган төгрөгийн элэгдэл байгуулж, 8,619.0 мянган төгрөгийн хөрөнгийг нэмж худалдан авсан байна.
- Программ хангамжийн анхны өртөг өмнөх оноос өөрчлөгдөөгүй, харин хуримтлагдсан элэгдэл 65.0 мянган төгрөгөөр буюу 75%-аар өсөж, энэ хэмжээгээр дансны үнэ буурсан байна.

Тайлант онд нийт өр төлбөр 12,743.5 мянган төгрөгөөр буюу 237.6%-аар өсөж 18,106.4 мянган төгрөг болжээ. Үүнээс урт хугацаат өр төлбөр буюу ХААН банкнаас авсан урт хугацаат зээлийн дүнгээр 18,105.8 мянган төгрөгөөр буюу 100%-аар өссөн бол богино хугацаат ажиллагсадтай холбоотой өглөг 5,362.3 мянган төгрөгөөр буюу 100% буурч 0.6 мянган төгрөг болсон зэрэг нөлөөлжээ. Үүнийг дэлгэрэнгүйгээр авч үзвэл,

- Тайлант онд тус нөхөрлөл нь 746.0 мянган төгрөгийн ХХОАТ-ын, 206,596.4 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалттай холбоотой, 6,400.0 мянган төгрөгийн нөөцийн бараа материал олж бэлтгэхтэй холбоотой, 48,842.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн худалдан авалттай холбоотой, 196,848.1 мянган төгрөгийн цалин хөлстэй холбоотой, 22,735.5 мянган төгрөгийн ажил олгогчоос төлөх НДШ-тэй холбоотой, 9,450.7 мянган төгрөгийн тогтмол зардалтай холбоотой, 1,896.7 мянган төгрөгийн хангамж, бараа материалын зардалтай холбоотой, 1,554.5 мянган төгрөгийн эд хогшил, урсгал засварын зардалтай холбоотой, 1,541.4 мянган төгрөгийн бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалтай холбоотой, 13,721.5 мянган төгрөгийн бусад бараа үйлчилгээний зардалтай холбоотой, 1,505.8 мянган төгрөгийн зээлийн хүүгийн зардалтай холбоотой, 64,714.8 мянган төгрөгийн урсгал шилжүүлгийн зардалтай холбоотой, 36,357.2 мянган төгрөгийн цалингийн суутгалтай холбоотой өр төлбөрүүд буюу нийт 612,910.8 мянган төгрөгийн өр төлбөр үүсэж үүнээс цалин хөлстэй холбоотой 0.6 мянган төгрөгийн өр төлбөрөөс бусад өр төлбөрүүд барагдсан байна.
- Түүнчлэн тус онд 22,120.0 мянган төгрөгийн урт хугацаат зээл авч, үүнээс 4,014.2 мянган төгрөгийн зээлийг барагдуулсан байна.

Тайлант онд цэвэр хөрөнгө 238,635.8 мянган төгрөгөөр буюу 209.1%-аар өссөн нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой юм. Тайлант онд Засгийн газрын сан дансанд өөрчлөлт ороогүй бөгөөд өсөлт нь зөвхөн хуримтлагдсан үр дүнтэй холбоотой байна.

Орлогын нэр төрөл	Хүснэгт 2. Орлогын үзүүлэлт /мянган төгрөг/			
	2020	2021	Өөрчлөлт	Хувь
Улсын төсвийн санхүүжилт	264,621.2	262,211.0	(2,410.2)	-0.9
Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт	39,128.3	277,100.6	237,972.4	608.2
Тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт	4,550.0	-	(4,550.0)	-100.0
Үндсэн үйл ажиллагааны орлогын санхүүжилт	2,657.0	6,741.0	4,084.0	153.7
Туслах үйл ажиллагааны орлогын санхүүжилт	2,284.9	3,726.6	1,441.8	63.1
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлэх орлого	-	2,700.0	2,700.0	100.0
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	59,251.8	105,595.0	636,539.2	1,074.3
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		590,196.0		
Нийт орлого	372,493.1	1,248,270.2	875,777.1	235.1

2021 онд тус нөхөрлөлийн нийт орлого өмнөх оноос 875,777.1 мянган төгрөгөөр буюу 235.1%-аар өссөн байна. Үүнд, улсын төсвийн санхүүжилт 2,410.2 буюу 0.9%-аар, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт 4,550.0 мянган төгрөгөөр буюу 100%, буурч, эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт 237,972.4 мянган төгрөг буюу 608.2%-аар үндсэн үйл ажиллагааны орлого 4,084.0 мянган төгрөгөөр буюу 153.7%-аар, туслах үйл ажиллагааны орлого 1,411.8 мянган төгрөгөөр буюу 63.1%-аар, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлэх орлого 2,700.0 мянган төгрөгөөр буюу 100%-аар, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 636,539.2 мянган төгрөгөөр буюу 1,074.3%-аар тус тус өссөн зэрэг нь нөлөөлжээ. Үүнийг орлогын нэр төрөл тус бүрээр шинжилбэл дараах байдалтай байна. Үүнд:

- Улсын төсвийн санхүүжилт 2,410.2 мянган төгрөг буюу 0.8%-аар буурсан нь хамрах тойрог болох Орхон аймгийн Баян-Өндөр сумын Их залуу, Яргуйт багийн хүн ам, өрхийн хөдөлгөөнтэй шууд холбоотой юм. Тайлант онд нийт 12,270 хүн амыг хамарсан тойрогт эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлсэн байна.
- Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт 2021 онд 237,972.4 мянган төгрөгөөр буюу 608.2%-аар өссөн нь өмнөх онд үзүүлж байсан 4 багц (гэрийн эмчилгээ, өдрийн эмчилгээ, оношилгоо шинжилгээ, сэргээн засах эмчилгээ)-ын санхүүжилт дээр нэмэгдэж Ковид 19 халдвартай холбоотой гэрийн эмчилгээ, дархлаажуулалт, ПГУ сорьц зэрэг үйлчилгээг нэмж үзүүлэхтэй холбоотой санхүүжилттэй холбоотой юм.
- Цар тахал, өндөржүүлсэн бэлэн байдал зэрэг цаг үеийн нөхцөл байдлыг харгалзан эрүүл мэндийн байгууллагын ажиллагсад “Эмч” дэд хөтөлбөрийн хүрээнд орон нутгаас урамшуулал үзүүлж 2,700.0 мянган төгрөгийг 2021 онд хуваарилж санхүүжүүлсэн байна. Харин өмнөх онд ЭМГ-аас 4,550.0 мянган төгрөгийн санхүүжилтийг тусгай шилжүүлгээр олгож байжээ.
- Төсөвт байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого өмнөх оноос харгалзан 4,084.0 мянган төгрөг, 1,441.8 мянган төгрөгөөр буюу 153.7%, 63.1%-аар тус тус өссөн нь Ковид 19-тэй холбоотой тест, ЭМГ-аас олгосон томоогийн илүү цагийн хөлсний санхүүжилт, эрүүл мэндийн ажиллагсад үзүүлсэн дэмжлэг, урамшууллын санхүүжилт, шинжилгээний орлогын өсөлттэй холбоотой байна.
- 2020 онд тус ӨЭМТ нь 59,251.8 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч байсан бол энэ онд үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлого 636,539.2 мянган төгрөг буюу 1,074.3%-аар өссөн байна. Энэ нь ЭМГ-аас үнэ төлбөргүй олгосон 590,196.0 мянган төгрөгийн Ковид 19-тэй холбоотой эрүүл мэндийн багц, эм боох материал, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй хүлээн авсан 105,595.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж зэрэгтэй холбоотой байна.

Үзүүлэлт	Хүснэгт 3. Зардлын үзүүлэлт /мянган төгрөг/			
	2020	2021	Өөрчлөлт	Хувь
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	315,861.7	1,009,634.4	693,772.7	219.6
УРСГАЛ ЗАРДАЛ	315,861.7	1,009,634.4	693,772.7	219.6
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	312,140.9	943,413.8	631,272.9	202.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	181,532.4	196,713.9	15,181.5	8.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,135.1	22,735.5	12,600.4	124.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,024.9	9,450.7	5,425.8	134.8

Хангамж, бараа материалын зардал	25,403.8	43,867.9	18,464.1	72.7
Нормативт зардал	64,418.5	636,551.9	572,133.4	888.2
Эд хогшил, урсгал засварын зардал	2,484.5	4,952.8	2,468.3	99.3
Томилолт, зочны зардал	1,218.4		(1,218.4)	-100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	243.7	1,541.4	1,297.7	532.5
Бараа үйлчилгээний бусад зардал	22,679.60	27,599.8	4,920.2	21.7
ХҮҮ		1,505.8	1,505.8	100.0
Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр		1,505.8	1,505.8	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,720.8	64,714.8	60,994.0	1639.3
Бусад урсгал шилжүүлэг	3,720.8	64,714.8	60,994.0	1639.3

Нийт зардал өмнөх оноос 219.6%-аар буюу 693,772.7 мянган төгрөгөөр өссөн байна. Тайлант он үйл ажиллагааны бус зардал гараагүй байна. Үйл ажиллагааны зардлын өсөлтөд бараа, ажил үйлчилгээний зардлын өсөлт 202.2%-аар буюу 631,272.9 мянган төгрөгөөр, хүү 1,505.8 мянган төгрөгөөр буюу 100%, урсгал шилжүүлэг 1,639.3%-аар буюу 60,994.0 мянган төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлсөн байна. Үүнд:

- ✓ Бараа, ажил үйлчилгээний зардлын өсөлтөд ажилчдын цалин хөлс 8.4%-аар буюу 15,181.4 мянган төгрөгөөр, НДШ-ийн зардал 124.3%-аар буюу 12,600.4 мянган төгрөгөөр, тогтмол зардал 134.8%-аар буюу 5,425.8 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардал 72.7%-аар буюу 18,464.1 мянган төгрөгөөр, нормативт зардал 888.2%-аар буюу 572,133.4 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 99.3%-аар буюу 2,468.3 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж 532.5%-аар буюу 1,297.7 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 21.7%-аар буюу 4,920.2 мянган төгрөгөөр тус тус өсөж, томилолт, зочны зардал 1,218.4 мянган төгрөгөөр буюу 100% буурсан зэрэг нь нөлөөлжээ.
 - ✓ Цалингийн болон ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлын өсөлт нь шинээр эмч, сувилагч, жолооч зэрэг 3 хүнээр орон тоог нэмэгдүүлсэн, Засгийн газраас үзүүлсэн НДШ-ийн хөнгөлөлтийн хуулийн хугацаа дууссан зэрэгтэй холбоотой байна.
 - ✓ Тогтмол зардлын өсөлтөд үйл ажиллагаа явуулж буй барилгын хүчин чадлын ашиглалт нэмэгдсэн нь нөлөөлсөн байна. Өөрөөр хэлбэл, 2020 онд 1 давхар, 399 м.кв талбай бүхий барилгад үйл ажиллагаагаа явуулж байсан бол 2021 онд зоорины давхрын хэсгийг оролцуулан 3 давхар шинэ барилгад шилжин үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн болно.
 - ✓ Хангамж, бараа материалын зардал өссөн нь цар тахлын үр нөлөөтэй холбоотой байна. Өөрөөр хэлбэл, дархлаажуулалтын цэг дээр очиж ажиллах, гэрээр эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, шинжилгээ авах, нэг удаагийн хөдөлмөр хамгааллын хэрэгсэл ашиглах зэргээр ашиглалтын зардал цар тахлын өсөлттэй холбоотой өсөж байжээ.
 - ✓ Нормативт зардал өссөн нь гэрийн эмчилгээний багц эм олгох хүн амын тоо цар тахалтай холбоотойгоор нэмэгдсэн, дархлаажуулалтын I болон II тун, вакцины хэрэглээ нэмэгдсэн зэргээс үүдэлтэй.
 - ✓ Эд хогшил, урсгал засварын зардал өссөн нь автомашинтай холбоотой эвдрэл гэмтэл, урсгал засвар үйлчилгээ гарсан, байр ашиглалттай холбоотой засвар үйлчилгээг хийсэн зэргээс шалтгаалжээ.
 - ✓ Томилолт, зочны зардал буурсан нь цар тахлын үед томилолтоор ажиллахыг хязгаарласантай шууд холбоотой юм.
 - ✓ Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн өсөлтөд банкнаас зээл авахтай холбоотойгоор зээлийн үйлчилгээ үзүүлсний шимтгэлд 663.6 мянган төгрөг төлсөн, өмнөх оны аудитаар илэрсэн зөрчлийг арилгахтай холбоотой 352.3 мянган төгрөгийн төлбөрийн актыг барагдуулсан зэрэг нөлөөлсөн байна.

- ✓ Бусад бараа үйлчилгээний зардлын өсөлт нь шинээр үндсэн хөрөнгө ашиглалтад авч элэгдлийн зардал өссөнтэй холбоотой.
- ✓ Тайлант онд шинээр урт хугацаа зээл авсантай холбоотойгоор 1,505.8 мянган төгрөгийн хүүгийн зардал гарсан байна. Энэ нь автомашин худалдан авахтай холбоотой авсан зээлийн хүүгийн зардалтай холбоотой юм.
- ✓ Урсгал шилжүүлгийн зардлын өсөлтөд бусад урсгал шилжүүлэг өмнөх оноос 1,639.3% буюу 60,994 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна. Энэ нь цар тахлын үед ажилласан, ажиллаж буй эмнэлгийн байгууллагын ажиллагсдад эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтээс 3 удаагийн урамшуулал олгосонтой холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар цэвэр хөрөнгийн нийт дүн 238,635.8 мянган төгрөгөөр буюу 209.1%-аар өссөн нь тайлант оны үр дүнгийн өсөлттэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Тус нөхөрлөл нь Төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан үйлчлэх хүрээнд тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол улсын Иргэний тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасны дагуу “Нөхөрлөл” нь ашгийн төлөө хуулийн этгээд бөгөөд Нөхөрлөлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, 24 дүгээр зүйлд заасны дагуу нөхөрлөлийн гэрээг байгуулж, ашиг алдагдал хуваах зарчмаа тодорхойлсон байдаг. Гэвч бодит байдал дээр тус нөхөрлөл нь тухайн тайлант хугацаанд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, түүнд нийцсэн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний орлого, зарлага, хөрөнгө оруулалт зэргийг багтаасан бизнес төлөвлөлтийг боловсруулан баталж ажиллаагүй, гүйцэтгэлийг үнэлж дүгнээгүй байна.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус нөхөрлөл улсын төсвийн санхүүжилтийг Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 17.1-д заасан аргаар тооцож, төсөвлөн батлуулдаг. Тайланд онд тус нөхөрлөл нь Орхон аймгийн Баян-Өндөр сумын Шанд баруун задгай 1-19 гудамж, Их залуу багийн 12,588 хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэхээр Орхон аймгийн Засаг дарга, Орхон аймгийн Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдөр улсын төсвөөс 262,210.9 мянган төгрөгийн санхүүжилт авах гэрээг байгуулсан байна.

Мөн Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 17.2-т тусгасан аргын дагуу эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих мөнгөн орлогыг хүлээн авдаг. Мөн энэ хуулийн 21.5-д заасны дагуу төлбөртэй үйлчилгээг үзүүлж мөнгөн орлогыг бүрдүүлж ажилладаг.

Уг улсын төсвийн санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар бүлэг, зүйл тус бүрээрх төлөвлөлт боловсруулагдаагүй байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийг хянах механизм бүрдээгүй бөгөөд тайлант онд улсын төсвөөс санхүүжүүлсэн 262,910.9 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлсэн 277,100.6 мянган төгрөг, өөрийн үйл ажиллагаанаас олсон 10,467.6 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжүүлсэн 2,700.0 мянган төгрөг, нийт 552,479.2 мянган төгрөгийн мөнгөн орлогоос байгууллагын урсгал үйл ажиллагаанд 533,896.1 мянган төгрөгийг, хөрөнгө оруулалтад 18,583.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллага нь нэмэлт санхүүжилтийн дансыг ашигладаггүй байна. Монгол улсын Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2021 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 05/А/12 дугаар тушаал “Коронавируст халдвар (Ковид-19)-ыг илрүүлэх шинжилгээг төлбөртэй хийх, шинжилгээний жишиг үнэ тогтоох, орлогыг зарцуулах заавар батлах тухай”-ын 3 дахь заалт “Коронавируст халдвар (Ковид-19)-ыг илрүүлэх шинжилгээ хийсэн төлбөрийг төрийн сангийн нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж дараах байдлаар зарцуулна” гэсэн байна. Гэвч тус нөхөрлөл нь нэмэлт төсвийн данс нээгээгүй, үндсэн санхүүжилтийн дансанд мөнгөн орлогыг цуглуулж, зарцуулалтыг тайлагнасан байгаа нь дээрх эрх зүйн баримтад нийцэхгүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус нөхөрлөл нь Орхон аймгийн онцгой байдлын комиссын 2021 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 732 тоот, Орхон аймгийн Эрүүл мэндийн газрын мөн өдрийн 01/436 тоот албан бичгүүдэд үндэслэн Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийн 30% буюу 9,480.0 мянган төгрөгийг ашиглан автомашин олж бэлтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2021 оны 67/А/268 дугаар тушаал “Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын дэгдэлтийн үед үзүүлэх цогц тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх журам”-ын 3.7, Монгол улсын Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2021 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 05/А/12 дугаар тушаал “Коронавируст халдвар (Ковид-19)-ыг илрүүлэх шинжилгээг төлбөртэй хийх, шинжилгээний жишиг үнэ тогтоох, орлогыг зарцуулах заавар батлах тухай”-ын 3.1-3.6 зэрэгт нийцэхгүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Гэвч бид дээрх асуудалтай холбоотойгоор аудитын дүгнэлтийг хязгаарлаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

1. Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлагналын тогтолцоотой холбоотой асуудал

Монгол улсын Иргэний тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 “*Ашгийн төлөө хуулийн этгээдийг нөхөрлөл, компанийн хэлбэрээр байгуулна*”, УСНББОУС-ын оршил “*Улсын секторын Нягтлан бодох бүртгэлийн стандартын цар хүрээ ба бүрэн эрх*”-ийн 10 дугаар параграф “*Дараах бүх шалгуурыг хангасан улсын секторын байгууллагуудад мөрдөхийн тулд УСНББОУС-ыг төлөвлөн зохиомжилдог*” гэсний (в)-д “*ашиг олох үндсэн зорилгогүй байх*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “*Энэ хуулийн 4.1.2-т заасан стандартыг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 5.1-д заасан шалгуур үзүүлэлтийг хангах аж ахуйн нэгж, байгууллага мөрдөнө*” гэсэнд нийцүүлэн тус нөхөрлөл нь ЖДААН-ийн СТОУС-ыг нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагнал, толилуулга, тодруулгад мөрдөх ёстой. Тиймээс тус нөхөрлөл нь санхүүгийн тайлан, түүний тодруулгыг Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 361 дугаар тушаал “*Маягт заавар батлах тухай*”-ын 1 дүгээр хавсралт “*Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар*”, 2 дугаар хавсралт “*Санхүүгийн тайлангийн А маягт*”-д нийцүүлж тайлагнавал зохино.

Мөн тус нөхөрлөл нь Төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т заасны дагуу төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарх ажил, үйлчилгээг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлдэг

тул Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан хугацаанд, 54 дүгээр зүйлийн 54.5-д заасан бүрэлдэхүүн хэсгүүдээр тайлагнах үүрэгтэй боловч 2021 онд төсвийн гүйцэтгэлийг тайлагнаагүй байна.

Нөхөрлөлийн нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлагнал, толилуулга, тодруулгууд нь УСНББОУС-ын дагуу илэрхийлэгдсэн, Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн гүйцэтгэлийг тайлагнаагүй зэрэг алдаа, зөрчил нь холбогдох хууль эрх зүй болон стандартад нийцэхгүй байна.

2. Нягтлан бодох бүртгэлийн программ хангамжтай холбоотой асуудал

Тус нөхөрлөл нь төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлд зориулан боловсруулагдсан CTS программыг ашиглаж байна. Энэ нь тус нөхөрлөлийн төсвийн гүйцэтгэлийн тайлагналд нийцэх боловч санхүүгийн тайлагналд үл нийцэж байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь Шилэн дансны тухай хуульд нийцүүлэн улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн талаарх улирлын мэдээллийг улирал бүр мэдээлэх үүрэгтэй. Тайланд онд тус байгууллага нь 262,210.9 мянган төгрөгийн улсын төсвийн санхүүжилтийн мэдээг мэдээлэхээс 1, 2, 4 дүгээр улирлуудын мэдээллийг шилэн дансанд байршуулаагүй байна. 3 дугаар улиралд өссөн дүнгээр 196,658.2 мянган төгрөгийн санхүүжилтийн мэдээллийг тайлагнасан байна.

Цаашид Шилэн дансны тухай хуулийн 4.1.3-т “*тогтсон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх*”, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоол “*Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандарт тогтоох журам*”-ыг тус тус хэрэгжүүлж ажиллахыг зөвлөж байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь 2021 оны 7 дугаар сарын 29-ны өдөр ХААН банкттай 22,120.0 мянган төгрөгийн 24 сарын хугацаатай зээлийн гэрээ байгуулж автомашин худалдан авсан байна. Үүнээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр 18,105.8 мянган төгрөгийн үүргийн үлдэгдэлтэй байна. Уг өр нь 2022 болон 2023 онуудын санхүүжилтээр төлөгдөхөөр хүлээгдэж байгаа, эдгээр онуудын төсөвт Төсвийн тухай хуулийн 6.3.3-т заасны дагуу дарамт учруулахуйц өр төлбөр байна.

Шилэн дансны хэрэгжилт, урт хугацаат өр төлбөрийн ирээдүйн төлөлт болон энэхүү тайлангийн аудитын илрүүлэлт хэсэгт тусгагдсан асуудлуудаас бусад хууль тогтоомжид нийцээгүй зүйл бидэнд ажиглагдаагүй болно.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчлийг барагдуулах 1 төлбөрийн акт, 1 зөвлөмж өгсөн ба хэрэгжилт 65.6 хувьтай байна.

Хүснэгт 4. Өмнөх аудитын үр дүнгийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	352.3	-	-	1	352.3	-
Албан шаардлага					-	-	-
Зөвлөмж	1	1,090.9	1	1,090.9	-	-	-
Нийт дүн	2	1,443.2	2	1,443.2	1	352.3	65.6%

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 04 дүгээр 08-ны өдрийн 11 тоот албан бичгээр Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар тус нөхөрлөлийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагнал, толилуулга, тодруулгад санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэх нь зүйтэй гэж үзлээ.

Мөн НЭМ-ийн төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд гүйцэтгэлийн аудитаар нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 381,842.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, материаллаг шинжтэй 13,488.6 мянган төгрөгийн алдаа зөрчилд төлбөрийн акт тогтоож, 368,353.9 мянган төгрөгийн материаллаг болон материаллаг бус алдаа зөрчилд 11 зөвлөмжийг хүргүүлэв.

4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлагналын олон улсын стандартын үл нийцэлтэй холбоотойгоор аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай холбоотой залруулгыг хийгээгүй болно.

4.2 Төлбөрийн акт

1. Өмнөх аудитын зөвлөмжтэй холбоотой асуудал

2020 оны аудитаар байгууллагын дарга өөртөө тушаал шийдвэргүйгээр нийт 352.3 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал цалин авсан байсан бөгөөд үүнийг Орхон аймгийн Төрийн сан дахь 100210000988 тоот /Ор.Хүү торгуулийн орлого/ дансанд төвлөрүүлэх төлбөрийн актыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газраас 2021 оны 3 дугаар сарын 15-ний өдрийн 55/55 ОРА-2021/7/СТА-БСД дугаар бүхий актаар тогтоосон байна. Үүнийг тайлант онд 2021 оны 6 дугаар сарын 14-ний өдөр нөхөрлөлийн мөнгөн хөрөнгөөр барагдуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д нийцэхгүй, аудитын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой асуудал

Цар тахалтай холбоотойгоор цалингийн урамшуулалд олгосон 56,300.0 мянган төгрөгөөс даатгуулагчаас төлөх НДШ-ийг суутгаагүй, ажил олгогчоос төлөх НДШ-ийг тооцоолж, тайлагнаагүйгээс нийт 14,081.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д нийцэхгүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.3 Албан шаардлага

Бидний гүйцэтгэсэн аудитын горим, сорилоор тус байгууллагын нягтлан бодох бүртгэл, тайлагналд албан шаардлага тогтоох түвшний материаллаг алдаа, зөрчил илэрхийлэгдээгүй болно.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт

2018 онд Нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг боловсруулсан боловч хууль болон стандартын шинэчлэлд уялдуулан нэмж засварлан шинэчлээгүй, үйл ажиллагаандаа дагаж мөрдөөгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2, 20.2.2-т нийцэхгүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн стандарт болон эрх зүйн орчны шинэчлэлтэд нийцүүлэн нэмж засварлан үйл ажиллагаандаа дагаж мөрдөх

2. Дотоод хяналттай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт

Тус нөхөрлөл нь дотоод хяналтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүйгээс дотоод хяналтын тогтолцоо сул байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19.1, Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн 311 дүгээр тогтоол “Нийтлэг журам батлах тухай (ААНБ-ын дотоод хяналт шалгалт)”-ын хавсралт “Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-д нийцэхгүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Зөвлөмж

Холбогдох эрх зүйн баримт бичигт нийцүүлэн дотоод хяналт, шалгалтын баримт бичгийн боловсруулан байгууллагын дотоод хяналтын үйл ажиллагааг төлөвлөж зохион байгуулах, тайлагнах тогтолцоог бий болгох

3. Төлөвлөлт, тайлагналтай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт

Тус нөхөрлөл нь байгууллагынхаа үндсэн үйл ажиллагааг төлөвлөдөггүй, гүйцэтгэл болон тайлагналын тогтолцоо бүрдээгүй байна. Түүнчлэн 2021 онд улсын төсвөөс санхүүжүүлсэн 262,210.9 мянган төгрөгийн зардлын гүйцэтгэлийг зардлын зүйл ангиар төлөвлөж, гүйцэтгэлийг тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1, Төсвийн тухай хуулийн 22.1, 16.5.7-д нийцэхгүй, аудитын тохиолдсон байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1 дэх заалтын дагуу байгууллагын удирдлагын зүгээс үйл ажиллагааг удирдан зохион байгуулах үүргээ биелүүлж, жил бүрийн үйл ажиллагааг төлөвлөж, тайлагнах, гүйцэтгэлийн үнэлэх тогтолцоог бий болгох, улсын төсвийн санхүүжилтийг Төсвийн тухай хуулийн 22.1, 16.5.7 дэх заалтуудад нийцүүлэн төсвийн шууд захирагчийн эрхийг хэрэгжүүлэх, төсвийн гүйцэтгэлийг тайлагнах

4. Шилэн дансны хэрэгжилттэй холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт

Шилэн дансанд мэдээлбэл зохих улсын төсвийн санхүүжилт 262,210.9 мянган төгрөгийн 4 мэдээллээс 3 дугаар улирлын улсын төсвийн санхүүжилтийн өссөн дүн болох 196,658.2 мянган төгрөгийн 1 мэдээллийг байршуулж, үлдсэн 65,552.7 мянган төгрөгийн улсын

төсвийн санхүүжилтийг мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.1 “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, “4.1.3 *“тогтсон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх”*, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоол “*Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандарт тогтоох журам*”-д нийцэхгүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2 Зөвлөмж

Шилэн дансны тухай хуульд нийцүүлэн мэдээллийг цаг хугацаанд нь иж бүрэн, үнэн зөв мэдээлж байх

5. *Татварын тайлагналтай холбоотой асуудал*

5.1 Илрүүлэлт

Тус байгууллагын санхүүгийн тайланд 2021 оны эхэнд 7,712.3 мянган төгрөгийн ХХОАТ-ын авлага, 5,256.2 мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөг, 106.7 мянган төгрөгийн НДШ-ийн өглөг, тайлант оны эцэст 889.9 мянган төгрөгийн ХХОАТ-тай холбоотой авлагуудыг тайлагнасан байна. Харин татварын албаны цахим тодорхойлолтоор тайлант оны эхэнд 1,161.1 мянган төгрөгийн агаарын бохирдлын төлбөрийн өглөг, оны эцэст 2,351.4 мянган төгрөгийн цалин хөлстэй холбоотой ХХОАТ-ын өглөг, 1,333.9 мянган төгрөгийн агаарын бохирдлын төлбөр, 3,208.3 мянган төгрөгийн ХХОАТ-ын авлага тайлагнагдаж, нийт 4,877.4 мянган төгрөгийн алдаа зөрчил үүссэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6, 20.2.7-д нийцэхгүй, аудитын эрх ба үүрэг, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2 Зөвлөмж

Татварын байгууллагатай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулах, зөрүүтэй илэрхийлэгдэж буй татварын өр, авлагатай холбоотой асуудлыг шийдвэрлэх

6. *Нийгмийн даатгалын тайлагналтай холбоотой асуудал*

6.1 Илрүүлэлт

2021 оны 1-ээс 6 дугаар саруудад тэтгэвэр тогтоолгосон ажилчид (10.3%)-ын нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг буруу (10.5%) тооцоолж цалингаас суутгал хийснээр 33.2 мянган төгрөгийг илүү суутгасан байна. Энэ нь нийгмийн даатгалын тайлан (тайланд зөв хувь хэмжээгээр тусгасан)-ийн дүнгээс дээрх дүнгээр зөрүүтэй илэрхийлэгдэж байна. Тайлант оны эхэнд НДШ-ийн 106.7 мянган төгрөгийн өглөгийг толилуулсан бол НДШ-ийн тайлангаар 6.4 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Эдгээр нь Нийгмийн даатгалын даатгалын тухай хуулийн 15.1, Сангийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2021 оны 49, А/39 дугаар тушаалын 2.26.9 “Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн төлөлтийн тайланд бүртгэх даатгуулагчийн төрөл, код”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6, 20.2.7-д нийцэхгүй, аудитын үнэлгээ ба хуваарилалт, тасалбар болголт, эрх ба үүрэг, оршин байх зэрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

6.2 Зөвлөмж

Даатгуулагч болон ажил олгогчоос тооцох нийгмийн даатгалын шимтгэлийн тооцооллыг алдаагүй үнэн зөв тооцоолох, тайлант хугацааны эцэст тооцоо нийлж баталгаажуулах

7. *Нягтлан бодох бүртгэл, анхан шатны баримт хөтлөлттэй холбоотой асуудал*

7.1 Илрүүлэлт

60.0 мянган төгрөгийн эм, 33.5 мянган төгрөгийн тооны машин, 142.9 мянган төгрөгийн ажил олгогчоос төлөгдөх НДШ зэргийг цалингийн зардлаар бүртгэсэн, 260.0 мянган төгрөгийн шатах тослох материалыг сэлбэг хэрэгсэл дансанд орлогоор бүртгэж, зарлагдсан байна. Мөн 20,451.9 мянган төгрөгийн бараа материалаарх хөрөнгө нь хүлээн зөвшөөрөгдсөн анхан шатны баримтаар баталгаажаагүй, бараа материалаар 2,399.6 мянган төгрөгийн НЭМ-ийн үйл ажиллагаанд зориулан худалдан авч зарцуулсан бараа материалын орлого, зарлагын баримтад тусгагдсан хөрөнгө болон төлбөрийн баримт (Е баримт) дахь гүйлгээний утга зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4, 13 дугаар зүйлд нийцэхгүй, аудитын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх зэрэг батламж мэдэгдэлд нийцэхгүй байна.

7.2 Зөвлөмж

Үнэн зөв анхан шатны баримтад үндэслэн ажил гүйлгээг ерөнхий журнал болон ерөнхий дэвтэрт үнэн зөв бүртгэх

8. Орлогын данстай холбоотой асуудал

8.1 Илрүүлэлт

2021 оны 1-ээс 6 дугаар саруудад Засгийн газраас үзүүлсэн ажил олгогчоос төлөх НДШ-тэй холбоотой чөлөөлөлтийн орлого болох 2,873.7 мянган төгрөгийн орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэж, тайлагнаагүй байна. Энэ нь ЖДААН-ийн СТОУС-ийн Бүлэг Бүлэг 24 “Засгийн газрын буцалтгүй тусламж”-д нийцэхгүй, аудитын иж бүрэн байх, тохиолдсон байх батламж мэдэгдэлд нийцэхгүй байна.

8.2 Зөвлөмж

Орлогыг иж бүрэн, үнэн зөв хүлээн зөвшөөрч бүртгэх, тайлагнах

9. Бараа материалын данстай холбоотой асуудал

9.1 Илрүүлэлт

Бараа материалаарх хөрөнгөд хамаарах эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур зэргийг жилийн эцэст тоолоогүй, 9,345.0 төгрөгийн Ковид 19-ын төстийн зарцуулалтыг нягтлан бодох бүртгэлд тусгаагүйгээс уг дүнгээр бараа материалын үлдэгдэл илүү тайлагнагдсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2.1, 14.4.6, 20.2.3-т нийцэхгүй, аудитын үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх, тасалбар болголт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

9.2 Зөвлөмж

Бараа материалын зарцуулалтыг нягтлан бодох бүртгэлд иж бүрэн, үнэн зөв тусгах, тайлагнах

10. Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал

10.1 Илрүүлэлт

Тус нөхөрлөл нь ашгийн төлөө байгууллага боловч ЖДААН-ийн СТОУС, Сангийн сайдын 2017 оны 361 дугаар тушаалд нийцсэн санхүүгийн тайланг бэлтгэдэггүй, УСНББОУС болон Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалд нийцүүлсэн санхүүгийн тайланг бэлтгэж, толилуулж ирсэн уламжлалт эрсдэл тогтсон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.3-т нийцэхгүй, аудитын иж бүрэн байх, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

10.2 Зөвлөмж

Байгууллагын үйл ажиллагааны хүрээнд үйлчилдэг хууль эрх зүйн орчинд нийцүүлэн дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн тайлагналын стандарт, үзэл баримтлал, бодлого, нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой эрх зүйн орчныг тодорхой болгох талаар орон нутгийн Санхүү төрийн сангийн хэлтэс, Эрүүл мэндийн газарт танилцуулж шийдвэрлүүлэх

11. Нягтлан бодох бүртгэлийн программ хангамжтай холбоотой асуудал

11.1 Илрүүлэлт

Тус нөхөрлөлийн нягтлан бодох бүртгэлийн программ хангамж нь төсөвт байгууллагад зориулагдсан байна. Мөн уг программ дахь орлогын тайлангийн оны эхний үлдэгдлийн мэдээлэл алдаатай, өмчийн өөрчлөлтийн тайланг зэрэгцүүлэгдэх мэдээллээр толилуулахгүй, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн мэдээллийг боловсруулахгүй байна. Энэ нь ЖДААН-ийн СТОУС, Сангийн сайдын 2018 оны 47 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт “Нягтлан бодох бүртгэлийн программ хангамжид тавигдах шаардлага”-д нийцэхгүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

11.2 Зөвлөмж

Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тодорхой болгох замаар үйл ажиллагааны онцлогт тохирсон программ хангамжийг нэвтрүүлж ашиглах, одоогийн ашиглаж программ хангамжийн хөгжүүлэлтэд анхаарал хандуулж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс						Зөвлөмж		/Мян.төгрөгөөр/
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага				
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	"Энхжих мандариваа" ӨЭМТ	13	382,787.2	-	-	2	14,433.3	-	-	11	368,353.9	

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:

"МӨНГӨ НӨӨЦ БАЯЛАГ АУДИТ" ХХК-ИЙН

АУДИТОР:

АУДИТОР:

ХЯНАСАН:

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР

ЗАХИРАЛ

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ

АУДИТОР:

Л.БААСАНДОРЖ
З.БАТТУЯА

Огноо:
Огноо:

Handwritten signature

М.БЯМБАДОРЖ
Б.БАЙГАЛ

Огноо:
Огноо:

Б.ЭРДЭНЭ

Огноо:

Ц.НАРМАНДАХ

Огноо:

